



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№119 /333/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.07.04

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛД 4000 ГАРУЙ АЛБА ХААГЧ ОРОЛЦОНО



Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100,101 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах "Төрийн далбааны өдөр"-т зориулсан цэргийн ёслолын жагсаалд оролцох Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын бүрэлдэхүүн бэлтгэлээ базаасаар байна. Энэ хүрээнд өнөөдөр өглөө үүрийн 04.00 цагт Сүхбаатарын талбайд нэгдсэн бэлтгэлээ хийлээ. Энэ удаагийн "Төрийн далбааны өдөр"-т зориулсан цэргийн ёслолын жагсаалд БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ШШГЕГ, ТТХГ, ТЕГ, ЦЕГ, ДЦШ, ХЗЦК, АЦК, ТХЦК, ҮБХИС, ДХИС зэрэг 14 байгууллагын 4000 гаруй алба хаагч оролцож байна.

Цэргийн ёслолын жагсаалыг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, Улаанбаатар цэргийн хүрээний дарга, бригадын генерал С.Ганбямба командлах бол тугийн чиглүүлэгчээр ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, тугнаар ЗХЖШ-ын ХШҮГ-ын дарга хурандаа Ж.Өсөхбаяр, Тугийн хамгаалагчаар ЗХЖШ-ын ХҮГ-ын дарга хурандаа С.Баяр-очир, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга хурандаа Д.Номт нар ажиллах юм. Энэ жилийн "Төрийн далбааны өдөр"-ийн цэргийн ёслолын жагсаал нь түүхэн ойнууд давхацсан жилд

зохион байгуулагдаж буйгаараа онцлог бөгөөд энэ хүрээнд Батлан хамгаалахын сайдын тушаалаар Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, "Төрийн далбааны өдөр"-т зориулсан цэргийн ёслолын жагсаалд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас оролцох салбаруудын дунд "Тэргүүний жагсаалч удирдлага, байлдааны тугийн бүрэлдэхүүн", "Тэргүүний жагсаалч салбар", "Тэргүүний жагсаалч эгнээ"-г анх удаа шалгаруулна. Энэ нь Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчин, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, цэргийн ёслолын жагсаалыг дүрэмч, жагсаалч, идэвх оролцоо, санаачилга, жигдрэлтийн байдлыг сайжруулах зорилготой юм.

Нэгдсэн бэлтгэлийн хүрээнд 7 дугаар сарын 6, 9-ний өдрүүдэд шөнийн цэргийн ёслолын жагсаалыг дахин зохион байгуулна.

Сонирхуулахад, цэрэг дайчдынхаа цогтой жагсаалын үзэх боломж олгодог цэргийн хүндэтгэлийн жагсаал тухайн улс орны тусгаар тогтнол, түүнийг батлан хамгаалах цэрэг, армийн хүчин чадлыг харуулсан чухал арга хэмжээний нэг юм. Улс орны сүр жавхаа болсон цэрэг дайчдын цог

золбоог илтгэн харуулдаг Цэргийн ёслолын жагсаалын түүхээс дурдвал анх жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар Монгол Улсад Ардын хувьсгал ялсан өдөр буюу 1921 оны долоодугаар сарын 11-ний өдөр Нийслэл хүрээнд анх удаа явуулж эхэлснээс хойш эдүгээ 91 жил болж байна. Энэхүү арга хэмжээ нь Зэвсэгт хүчний хөгжлийн үе шатуудад тасралтгүй явагдаж чадаагүй ч 1970-



аад оноос 1991 он хүртэл жанжин Д.Сүхбаатарын талбайд тогтмол явагдсаар иржээ. Тухайлбал Батлан Хамгаалахын Сайдын 1971 оны 170 дугаар тушаалаар "Ардын армийн 50 жилийн ойн цэрэг техникийн парад", 1986 оны 245 дугаар тушаалаар "Ардын хувьсгалын 65 жилийн ойн зэвсэг, техникийн парад", 1991 оны 261 дүгээр тушаалаар "Ардын хувьсгалын 70 жилийн ойн баярын цэргийн парад"-ыг тус тус явуулж байсан ба Ардын хувьсгалын ойн баяр наадмын тэгш ойн жилүүдэд цэрэг, техникийн, харин ойн бусад жилүүдэд зөвхөн цэргийн алба хаагчдын ёслолын жагсаал тус тус явагддаг байжээ. Түүнчлэн тухайн үед Октябрийн хувьсгал ялсны буюу Октябрийн баярын өдөр мөн нэгэн адил цэргийн ёслолын жагсаал явагдаж байсан ажээ.

Цэргийн ёслолын жагсаал нь 1991 оноос хойш түр тасарч байгаад 1996 онд Монголын тулгар төр байгуулагдсаны 790, Ардын хувьсгалын 75 жилийн их ойн баяр наадмын нээлтийн үеэр Төв цэнгэлдэх хүрээлэнд нэг удаа зохион байгуулагдаж байжээ. Үүнээс хойш есөн жил завсарласны дараа 2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн тангараг өргөх ёслолын үеэр Зэвсэгт хүчний анги байгууллага, Хил хамгаалах ерөнхий газрын болон Дотоодын цэргийн ангиуд оролцсон цэргийн ёслолын жагсаалыг жанжин Д.Сүхбаатарын талбайд явуулсан байна. Дараа нь 2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн тангараг өргөх үед цэргийн ёслолын жагсаалыг явуулсан нь тухайн үед ард иргэд, залуучуудын гүн талархлыг хүлээсэн ёслолын арга хэмжээ болсон байна. Тэрчлэн 2009 онд "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай" Монгол Улсын хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу Монгол Улсын "Төрийн далбааны өдөр" буюу долоодугаар сарын 10-ны өдөр цэргийн ёслолын жагсаалыг дахин явуулж эхэлсэн юм. Цэргийн ёслолын жагсаалыг дэлхийн ихэнх улс орон тэмдэглэлт баярынхаа үеэр бэлтгэн, зохион байгуулан явуулдаг бөгөөд энэхүү арга хэмжээг тухайн улс орны тусгаар тогтнол, түүний батлан хамгаалах цэрэг, армийн хүчин чадлыг харуулсан чухал арга хэмжээний нэг гэж үздэг ажээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	🌙 10


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌙 24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.148.00	3.153.0
EUR 🇪🇺	3.305.0	3.320.0
CNY 🇨🇳	472.00	474.00
RUB 🇷🇺	53.50	54.80
JPY 🇯🇵	23.10	23.40
KRW 🇰🇷	2.42	2.45

ЗУРХАЙ



2022.07.04 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 5

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Эд, мал арвижна

Наран ургах, шингэх:

04.59-20.54

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал: Мод

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, гарагийг тахи, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой, Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 554,387,542

Эдгэрсэн

Нийт: 529,268,250

Нас барсан

Нийт: 6,361,436

Цахим шууданд

“ОПЕРАТОР-ЗАСВАРЧИН МЭРГЭШҮҮЛЭХ ДАМЖАА”-НД ХАМРАГДСАН АЛБА ХААГЧИД ГЭРЧИЛГЭЭГЭЭ ГАРДАН АВЛАА



Найман жилийн хугацаанд мэргэжлийн алба хаагч бэлтгээгүй “Сургалтын төвийн оператор бэлтгэх дамжаа”

Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийг түшиглэн өнгөрөгч 6 дугаар сарын 20-ны өдрөөс энэ сарын гуравны өдрийг хүртэл 14 хоногийн

хугацаанд амжилттай хичээллэж өндөрлөлөө. 2014 оноос хойш “Оператор, засварчин” бэлтгэх сургалт явагдаагүй

учир бусад нэгтгэл, ангиудад энэ чиглэлийн мэргэжлийн алба хаагч нэн дутмаг байна. Жишээлбэл, танкын буудлагын талбай, явган цэргийн байлдааны машины буудлагын талбайн аль алиныг том бууны буудлагын талбай гэж хүмүүс ойлгодог. Гэвч бодит байдалд тэдгээр дээргүйцэтгэдэгдасгалууд, талбайг төхөөрөмжлөх тоноглолууд, буудлага боловсруулах зарчим нь харилцан адилгүй байдаг. Гэтэл тэр бүгдэд мэргэжлийн хүмүүс орж ажилладаггүй учраас холын нэгтгэл, ангиудын буудлагын полигонуудын төхөөрөмжүүдэд эвдрэл, гэмтлүүд ихээр гарах, техник технологио бүрэн гүйцэт ашиглаж чадахгүй учир хадгалалтын байдалд байлгадаг нөхцөл байдал түгээмэл байгааг холбогдох албаны хүмүүс онцоллоо.

ОПЕРАТОРЧИН БЭЛТГЭДЭГ АНГИ МАНЙХААС ӨӨР БАЙХГҮЙ

Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Хээрийн сургалтын төвийн дарга дэд хурандаа Ц.Батзул:



Мэргэжлийн Оператор-засварчин бэлтгэх, мэргэшүүлэх сургалтад Зэвсэгт хүчний 20 гаруй нэгтгэл, ангийн 28 ахлагч, 5 хугацаат цэргийн алба хаагч, хоёр ангийн ажилчин албан хаагч буюу нийт 35 алба хаагч энэхүү сургалт, дамжаанд амжилттай хамрагдлаа. Эдгээр хүмүүс энд сурч мэдсэн зүйлсээ өөрийн нэгтгэл, ангидаа хэрэгжүүлэх зорилготой юм. Тухайлбал, ангийнхаа буудлагын талбайг тоноглох, засаж сайжруулах, ажиллахгүй байгаа зүйлсийг ажиллагаанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлэх болон бусдадаа зааж сургах гэх зэрэг чухал үүрэгтэй. Цаашдаа энэ чиглэлийн мэргэжлийн офицер, ахлагч, алба хаагчдын тоог идэвхтэй нэмэгдүүлэх, бэлтгэх нэн шаардлагатай байгаа юм. Гэтэл “Ахлагч

бэлтгэх төв”-д энэ чиглэлээр алба хаагчдыг бэлтгэдэггүй, цаанаас нь албан ёсны орон тооны захиалгыг гаргаж өгдөггүй. Хоёрдугаарт, бэлтгэгдээд мэргэжлийн өндөр түвшинд боловсорсон хүчгүй энэхүү мэргэжлийн алба хаагчийн тоо бараг байхгүйтэй ижил түвшинд хүрээд байна. Уг мэргэжлийн алба хаагчийг бэлтгэдэг газар манайхаас өөр байхгүй. Манайх ч энэ чиглэлээр алба хаагчдыг тогтмол бэлтгэдэггүй. 2014 оноос хойш тасраад байсан операторын дамжаа энэ жилээс л сэргэж ийнхүү 35

МИНИЙ МӨРӨӨДӨЛ БИЕЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн дэд түрүүч Д.Анхбаяр: -Сургалт маш гоё, бас чанартай явагдлаа. Багш нар маань бүхий л зүйлийг чин сэтгэлээсээ зааж сургасан. Мөн аюулгүй ажиллагааны дүрмийг алхам тутамдаа дагаж мөрдөхийг шаардаж байсан. 14 хоногийн хугацаа бага ч гэсэн чамлахааргүй их зүйлийг сурч авсан гэж бодож байна. Багаасаа л цэргийн хүн болохыг хүсэж мөрөөддөг байлаа. Өмнө нь УБХИС-д элсэн суралцахаар бэлдсэн ч чадаагүй юм. Тиймээс мөрөөдлөө биелүүлэн хугацаат цэргийн алба хааж, тэндээсээ үргэлжлүүлэн улирч улмаар ахлагч болохоор шийдсэн. Тийм ч учраас цэргийн албанаас огт шантраагүй. Миний цэргийн операторчин. Монгол Улсын Зэвсэгт хүчний бүхий л нэгтгэл, ангийн буудлага, марш-тактикийн тэмцээн болгон полигоноор дамждаг. Үүнээс харахад л энэ чиглэлийн мэргэжил эрэлттэй чухал мэргэжил шиг санагддаг. Цаашдаа энэхүү мэргэжилдээ

эзэн нь байж ирээдүйд улс, эх орондоо шинийг зохион бүтээсэн, манлайлагч алба хаагч байхыг хүсэж байна. Үеийн нөхөд, дүү нартаа хандаж хэлэхэд цэрэг байх нь цэгцтэй, дэг журамтай болоход сургадаг юм билээ. Нэг л мэдэхэд алхаа гишгээ хүртэл цэгцрээд, олны дунд биеэ зөв авч явах талаар төлөвшөөд ирдэг. Тийм болохоор цэрэг чамайг эр хүн болгоно гэж хэлэхгүй. Яагаад гэвэл чин эр хүн. Харин зөв хүн болоход чинь тусална гэж хэлмээр байна. Ийнхүү сургалтын үйл ажиллагааг хааж ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын орлогч дарга хурандаа Д.Жигжидсүрэн төгсөгчдөд мэргэжлийн гэрчилгээг гардуулан өгч, үг хэлсэн юм. Тэрээр сургалтад хамрагдсан алба хаагчдад хандан сурч, мэдсэн зүйлдээ эзэн нь байж, эзэмшсэн мэдлэг чадвараа улам өргөжүүлж, өөрийн нэгтгэл, ангидаа холбогдох мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэдэг байхыг захиад, цаашдын ажилд нь өндөр амжилтыг хүссэн юм.

Ө.НАСАНТОГТОХ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ ДАЙЧИД АРХАНГАЙ АЙМАГТ ОЧЛОО



Архангай аймгийн Тамгын газрын цахим хуудаст орон нутагт нь томилогдон ирж байгаа Зэвсэгт хүчний дайчдыг хадаг, сүү барин угтан авсан тухайгаа мэдээлжээ. Орон нутагт нь цэргийн анги байгуулагдсанд талархаж буйгаа ч уламжилжээ. Засгийн газрын шийдвэрийн дагуу бүтээн байгуулалт, экологийн чиглэлээр дагнасан Зэвсэгт хүчний дугаар ангийг байгуулахаар болсон билээ. Тус ангийн захирагч, дэд хурандаа Д.Зоригтсайханаар ахлуулсан эхний ээлжийн

бие бүрэлдэхүүн өчигдөр зорьсон нутагтаа очсон байна. Бүрэлдэхүүнийг ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтсийн дарга, хурандаа Н.Гантөмөрөөр ахлуулсан албаныхан орон нутагт хүлээлгэн өгчээ. Ташрамд дурдахад, дэд хурандаа Д.Зоригтсайхан нь төмөр замын бүтээн байгуулалтад манлайлж удирдан оролцсон бөгөөд цэргийн инженерээр мэргэшсэн алба хаагчийн нэг юм. Томилполт өвөртлөн мордсон бүтээн байгуулагч дайчдын зорьсон үйлс саадгүй бүтэж ээ...

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ ЗҮЙЛСИЙГ УСТГАВ



Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Дорноговь аймгийн Алтанширээ суманд үйл ажиллагаа явуулдаг “Газопровод Союз восток” ХХК-ны байгалийн хийн хоолойн урьдчилсан байдлаар тогтоосон зурвас өнгөрсөн сарын 27-ны өдөр ажиллагаатай байж болзошгүй 2 ширхэг мина илэрсэн бөгөөд холбогдох арга хэмжээг авч өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу ЗХЖШ- тушаалаар Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн Тэсэрч дэлбэрэх зүйлсийн хайгуул устгалын бүлэг тухайн газар оронд ажиллав. Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ТДЗХУ-ын

бүлэг 6 дугаар сарын 28,29-ны өдрүүдэд тухайн газар оронд 2 километр квадрат газарт хайгуул хийж ОХУ-д үйлдвэрлэгдсэн явган цэрэг эсэргүүцэх ПМН-2 мина 12 ширхгийг, үүнээс байлдааны 4 ширхэг /тэсрүүлэгчтэй/, сургуулийн 8 ширхэг, мөн ОХУ-д үйлдвэрлэгдсэн танк эсэргүүцэх ТМ-62 мина 40 ширхгийг, үүнээс байлдааны 25 ширхэг /тэсрүүлэгчтэй/, байлдааны 15 ширхэг /тэсрүүлэгчгүй/-ийг илрүүлэн устгаж аюулгүй болгосон юм. Дээрх ажиллагааг явуулахад Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газар, Алтанширээ сумын ЗДТГ-аас холбогдох албан тушаалтан байлцлаа.



ЗҮГ ЗҮГИЙН ЗҮС ТАНИХГҮЙ ЗАЛУУСААС ИХИЙГ СУРЧ МЭДСЭН 14 ХОНОГ БАЙЛАА

Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн ахлах ахлагч Ш.Нямбаяр:

-Бид 32 цагийн онол, 88 цагийн дадлага буюу нийт 120 цагийн хичээл, сургалтад хамрагдлаа. Дадлагын

хичээлээр ЯЦБМ-ны буудлагын талбайн тоног төхөөрөмжийг хийж, төмөр замыг ашиглалтад орууллаа. Дамжааны

туршид бид туршлага солилцож өдөр бүр шинэ зүйлсийг сурсан нь ололттой тал байж чадлаа. Цаашдаа энэхүү

сургалтаас олж авсан мэдлэг чадвараа өөрийн ангид хэрэгжүүлэх бүрэн чадварыг эзэмшсэндээ баяртай байна.